

Дундговь аймгийн Өлзийт сумын
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны
12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны
149 дугаар тогтоолын хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2018 - 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

№	Нийлүүлэх бүтээгдэхүүн	Хугацаа	Хариуцах эзэн		
Зорилт: Хүний хөгжилд суурилсан, иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжсэн, үйлдвэрлэл хөгжүүлсэн, Эко орчин бүрдүүлэх зорилт тавин ажиллана.					
Зорилтод хүрэхийн тулд дараах 4 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.					
1	Хүний хөгжилд суурилсан, Иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжиж ажиллах хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр				
2	Үйлдвэрлэл хөгжүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр				
3	Эко орчин бүрдүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр				
4	Шатар хөтөлбөр				

Нэг. Хүний хөгжилд суурилсан, Иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжиж ажиллах хөтөлбөр					
1	Сургуулийн суралцагчдын тоог нэмэгдүүлэх, багш нарын чадварыг сайжруулах, сурагчдын ая тухтай сурч, төлөвших орчныг бүрдүүлэх, дугуйлан секц, олимпиадуудыг тогтмолжуулж, хамран сургах үйлчилгээг сайжруулна.	Жил бүр	А.Эрдэнэбат М.Болормаа		
2	Монгол ахуй, уламжлал, ёс заншил, түүх соёлын онцлогийг хадгалсан хүүхэд хөгжлийн өргөөтэй болж, халаалтын асуудлыг шийдвэрлэнэ.	Жил бүр	А.Эрдэнэбат М.Болормаа		
3	“Үдийн цай” хөтөлбөрийг чанаржуулж, ариун цэврийн шаардлагыг хангаж ажиллана.	Жил бүр	А.Эрдэнэбат М.Болормаа		
4	Ахмад настан, залуучууд, хүүхэд багачуудын гурван үеийн алтан хэлхээг бэхжүүлэх ажлыг монгол ёс заншил, уламжлалд тулгуурлан хэрэгжүүлнэ.	2018 он	СӨБ, Ахмад багш нар		

5	Хүүхэд нэг бүрийн авьяасыг нээж, хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах	тогтмол	СӨБ-ын багш ажилчид		
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үйл ажиллагааг дэмжин ажиллана	тогтмол	СӨБ-ын багш ажилчид		
7	Багийн Засаг дарга нарыг мэргэшүүлэх, дадлагажуулах, иргэдэд хүрч ажиллуулах, ЗДТГазар түүний албадын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж үр нөлөөг дээшлүүлэн чанартай болгоно.	Жилдээ	А.Эрдэнэбат Б.Хорлоо		
8	Орон нутаг дахь иргэний нийгмийн байгууллага, иргэдийн нөхөрлөлтэй байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажиллах тогтолцоог шинэ шатанд гаргана.	Жил бүр	Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагчид		
9	Малчин залуучуудын чуулга уулзалт зохион байгуулах	10-р сард /2 жил тутам/	ЗДТГ, БЗД нар Залуучуудын холбоо		
10	Малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөн зохион байгуулах	2-р сард /2 жил тутам/	ЭХолбоо, ЗДТГ		
11	Багийн Засаг дарга нарыг унаажуулах	Жилдээ	А.Эрдэнэбат		
12	Эрүүл мэндийн төвийн барилгыг их засварт оруулах	жилдээ	Ж.Рэнчинсамбуу		
13	Багийн эмч нарыг унаажуулах	жилдээ	А.Эрдэнэбат Ж.Рэнчинсамбуу		
14	Лаборантаар тогтвор суурьшилтай ажиллах боловсон хүчнийг бэлтгэнэ.	жилдээ	Ж. Рэнчинсамбуу		
15	Төрийн албан хаагчдын орон сууцтай болох, нийтийн цэвэр бохирт холбогдсон байх	Жилдээ	А.Эрдэнэбат		
16	Эрүүл мэндийн төвийн ажилчдыг зөөврийн компьютертэй болгоно.	жилдээ	А.Эрдэнэбат		
17	Халдварт бус өвчлөлийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 80%-тай хийнэ. /Элэгний В,С 16-40 нас АД, Чихрийн шижин, Умайн хүзүү Хөхний өмөнгийн үзлэг гэх мэт/	Тогтмол	Ж.Рэнчинсамбуу		
18	Сумын Сайн малчин, Тэргүүний залуу малчин шалгаруулж урамшуулах	Жилдээ	ЗДТГ, БЗД нар		
19	Орон гэр хүссэн өргөдөлийн дагуу иргэдийн саналыг хүлээн авч шийдвэрлэж байх	Жилдээ	А.Эрдэнэбат Б.Хорлоо		
20	Багуудын нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулна.	Жил бүрийн 5-р сард	А.Эрдэнэбат Б.Хорлоо БЗД нар, малчид		

21	Сурагчдын авьяас чадвараа хөгжүүлэн уралдаан тэмцээнд явахад нь зориулан унааны асуудлыг шийдвэрлэх Спортын холбоод болон спорт хамтлагийн үйл ажиллагаагдэмжижи хамтран ажиллана.	Жил бүр	А.Эрдэнэбат М.Болормаа	
22	Хүүхэд хамгааллын ажлыг эрчимжүүлэн “Ногоон гэрэл- цагаан шугам” аяныг зохион байгуулж замын хөдөлгөөнд соёлтой оролцоно.	Жил бүр	А.Эрдэнэбат М.Болормаа	
23	“Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөөе” аяныг өрнүүлэн гэрчилгээ олгоно.	Жилдээ	А.Эрдэнэбат Ц.Хадхүү Б.Оюунханд	
24	Соёлын төвийн номын санг МУ-ын Төрийн шагналт, дэлхийн гайхамшигт яруу найрагч Д.Нямаагийн нэрэмжит номын сан болгоно.	Жилдээ	Х.Отгонмөнх А.Эрдэнэбат Ц.Хадхүү	
25	Соёл урлагийн байгууллагууд, ЕБС, СӨБ-д ажиллаж байгаа мэргэжлийн бус хөгжмийн багш нарыг аймгийн бодлогоор мэргэжлийн их, дээд сургуульд суралцуулан, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулан боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Аймгийн ЗДТГ А.Эрдэнэбат Ц.Хадхүү	
26	“Шатар” хөтөлбөрийн хүрээнд хүүхэд залуучуудыг сургах	Жилдээ	ЗД, ИТХ, байгууллагууд	
27	Сургуулийн Урлаг залыг тохижуулж техник хэрэгслээр ханган сурагчдын урлагийн авьяасыг хөгжүүлэн ажиллана.	Жил бүр	А.Эрдэнэбат М.Болормаа	
28	Нийтийн байрны дээвэр, хаалга, сантехникийн бүрэн шинэчлэл хийж, Төрийн албан хаагчдын амьдрах ая тухтай орчин бүрдсэн нийтийн орон сууцаар хангаж ажиллана.	2018-2020	Засаг дарга А.Эрдэнэбат, захирал М.Болормаа	
29	ЕБСурагчдын дотуур байрны тасгуудын хаалгыг бүрэн шинэчлэх	2018-2020	А.Эрдэнэбат М.Болормаа	
30	Сумын нутаг дэвсгэрт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг аймаг сумын хамгаалалтанд авахуулан хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	Хөтөлбөр ийн хүрээнд	А.Эрдэнэбат Ц.Хадхүү М.Ганчимэг	
30	СӨБ-ын хамран сургалтыг 88%-д хүргэх	Жилдээ	СӨБ	
31	“Хүүхдэд ээлтэй” баг байгуулага шалгаруулна.	3-р улиралд	ЕБС, СӨБ, Баг, байгууллагууд	
32	Цэцэрлэгийн нэг ангийг урлаг спортын зал болгон тохижуулах	Жилдээ	СӨБ	
33	Хүүхдийг зам тээвэр ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль цэцэрлэгийн орчинд замын гэрэлтүүлэг тэмдэг, тэмдэглэл хийх, сэргээн засварлах сурагчдын замын хөдөлгөөний аюулгүй оролцох зөвлөмж сурталчилгааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	1,2,3 дугаар улиралд	СӨБ, ЕБС	
34	Орон нутгийн боловсролын байгууллагын хүний нөөцийн	Жилдээ	СӨБ, ЕБС	

	чадавхийг бэхжүүлэх			
35	Онцгой байдлын үед боловсролын байгууллагын бэлэн байдлыг хангах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургууль цэцэрлэгийн чадавхийг бэхжүүлж ажлыг мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулна.	2-р улиралд	СӨБ, ЗДТГ	
36	Нийгмийн даатгалын хууль, холбогдон гарсан тушаал шийдвэр, хууль сурталчлах ажлыг сумын эрх зүйн багаар дамжуулан хийхэд шаардах хөрөнгө санхүүгээр тусалж дэмжинэ.	Жил бүр	НД-ын байцаагч Г.Уранчимэг	
37	Жил бүр татвар төлөгчийн аян зохион байгуулж, шилдэг хөрөнгө оруулагч, шилдэг татвар төлөгчийг шалгаруулж ажиллана.	Жил бүр	Татварын Улсын байцаагч А.Ганзаяа	

Хоёр. Үйлдвэрлэл хөгжүүлэх хөтөлбөр

1	Малын гаралтай бүтээгдэхүүн болон цагаан идээний үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	Жил бүрийн 9-р сард	МЭҮТ, БЗД, ЗДТГ	
2	“Тэмээчдийн баярыг тэмдэглэж тэмээ өсгөсөн малчдыг дэмжин ажиллаж тэмээний ноос, сүү зэрэг ашиг шимийг нэмэгдүүлж тэмээний тоо толгойг өсгөнө.	2 жил тутамд 1удаа	ЗДТГ, БЗД нар, малчид, бизнес эрхлэгчид	
3	Нийтийн байр, орон сууц, гудамж талбай зэрэгт шаардлага хангасан хогийн сав бункер байрлуулах	жилдээ	А.Эрдэнэбат Ө.Буд-Очир	
4	Буянтын 1,2-р багийн соёлын төвийг засварлаж тоног төхөөрөмжөөр хангах	жилдээ	ЗДТГ, БЗД нар	
5	Соёлын төв ордон шинээр барих ажлыг эхлүүлэх /400 хүний багтаамжтай, 2 давхар/	2018-2020	А.Эрдэнэбат	
6	Засаг даргын Тамгын газрын их засварын ажил /150 сая/	2018	А.Эрдэнэбат Б.Хорлоо	
7	Засмал замд камержуулалт байршуулах	Жилдээ	А.Эрдэнэбат Цагдаагийн хэсэг	
8	Хуурай сүүний үйлдвэр байгуулна	2018	А.Эрдэнэбат Төсөл хэрэгжүүлэгч байгуулага	
9	Сумын төвийн гэр хорооллыг цэгцэлж жигдрүүлэх	2-р улиралд	ИТХ, ЗДТГ, БЗД нар, иргэд	
10	Архивын өрөө тасалгааг стандартын дагуу тохижуулах	Жилдээ	Б.Хорлоо А.Түмэндэмбэрэл	
11	Мал эмнэлгийн үйлчилгээ, үйл ажиллагаа явуулахад малчдын	Жилдээ	МЭҮТ	

	оролцоо хариуцлагыг сайжруулна.		БЗД нар		
12	Малжуулах хөдөлгөөнийг тогтмол өргөн хүрээтэй, үр ашигтай хэрэгжүүлнэ.	Жилдээ	МЭҮТ БЗД нар		
13	Мал аж ахуйн ашиг шимийг сайжруулах зорилгоор өндөр ашиг шимийн фермерийн аж ахуйг дэмжиж ажиллах, гойд ашиг шимт малын цөм сүргийн тоо толгойг өсгөнө.	Жилдээ	МЭҮТ БЗД нар		
14	Ус Цэвэршүүлэх байгууламж болон халуун усны байшинг бодлогийн шугамаар ажиллуулж байнгын ажлын байртай болгох	жилдээ	А.Эрдэнэбат Ө.Буд-Очир		
15	Малын гоц халвдарт шүлхий, цэцэг өвчний голомттой болсон тул мал хамгаалх санд төсвөөс мөнгө суулгаж өгөх	Жилдээ	МЭҮТ		
16	Гадны аймаг сумаас ашиг шим сайтай хээлтэгч, хээлтүүлэгч мал худалдан авах	Жилдээ	МЭҮТ		
17	Улс, аймгийн үзэсгэлэн худалдаанд ашиг шимт малтай оролцох /Малын удмын сан, эрүүл мэндийн хамгаалах тухай хууль/-ийг барьж ажиллана.	Жил бүр	МЭҮТ БЗД нар		
18	Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй зээлдэгч нарын зээлийг төлж барагдуулах, зохих хуулийн дагуу шийдвэрлэх	Жил бүр	МЭҮТ, ЖДҮХМ		
19	Сумын жижиг дунд үйлдвэр, сум хөгжүүлэх сангаас зээл авч байгаа иргэд, аж ахуйн нэгжийг татвар, нийгмийн даатгалд бүрэн хамруулна.	Жил бүр	МЭҮТ, ЖДҮХМ		

Гурав. ЭКО ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

1	Сумын хэмжээнд эдийн засаг нийгэм, байгаль орчны суурь судалгаа гарган, уул уурхайгаас үзүүлж буй нийгмийн нөлөөллийг тодорхойлж хөтөлбөр боловсуулж хэрэгжүүлнэ.	Жилдээ	ИТХ, ЗДТГ, БЗД нар судалгааны байгууллагууд		
2	Усны хайгуул хийх, инженерийн хийцтэй болон гар худаг гаргах, сэргээн засварлах, булаг шандын эхийг хаших зэргээр бэлчээрийн хангамжийг нэмэгдүүлнэ.	Жил бүр	ЗДТГ, БЗД нар,		
3	Загийн ойг хамгаалах хортон шавьж үлийн цагаан оготноос хамгаалах талаар төсөл хөтөлбөртэй хамтрч ажиллана.	Жилдээ	ЗД,БХ, Газрын даамал, БЗД		
4	Хилийн цэс тогтоогоогүй үлдсэн газар нутгуудыг тогтоох	Жилдээ	ЗД,БХ, Газрын даамал,БЗД		
5	Хүүхдүүдэд хог хаягдлын талаар цогц ойлголт өгөх, ЕБС, СӨБ-д хичээлийн програмд суулгаж өгөх, ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж самбар байрлуулах		М.Ганчимэг Ц.Наранбаатар		
6	Хогийг зориулалтын цэгтэй болгон янзалж, зохион байгуулалтад оруулан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэх хариуцлагын тогтолцоо бий болгоно.	жилдээ	А.Эрдэнэбат Ө.Буд-Очир		
6	Цөлжилт, элсний нүүдлийн эсрэг бэлчээр хаших, гүний худаг ус гаргах, энгийн уурхайн худаг засварлах төсөл хөтөлбөрүүдтэй	Жилдээ	ЗДТГ, БЗД нар, малчид		

	хамтарч ажиллах			
7	Мал эмнэлгийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж дэмжиж ажиллах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, бусад үйлчилгээнд бүрэн хамруулна.	Жилдээ	МЭҮТ	
8	Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд өвс тэжээлийн хэмжээг нэмэгдүүлж, эргэлтийг санг нэмэгдүүлнэ.	Жилдээ	МЭҮТ	
9	“Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлага”-ыг хэрэгжүүлж, иргэдэд нээлттэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, гурван талт нээлттэй хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулах, орон нутгаас ажлын байраар хангах тэдний нийгмийн даатгал, татварыг орон нутагт байрлуулах	Жил бүр	ИТХ, Газрын даамал, БОУБ	

10	Гадны төсөл хөтөлбөрүүдийг татах, ТББ-ууд, нөхөрлөл, хоршоог байгуулахад дэмжиж, бүлэг хоршоог нэмэгдүүлнэ.	Жил бүр	Газрын даамал	
11	Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгт хүрээлэн бий болгоно	Жил бүр	Байгаль орчны байцаагч	
12	Ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэн, “Ногоон соёл иргэншил” үзэл баримтлал, хөтөлбөрийн дагуу боловсруулж, загваруудыг бий болгоно.	Жил бүр	Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагчид	
13	Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх хүний аюулгүй байдалд халдсан, цацраг идэвхт болон химийн хорт бодисын хэрэглээг багасгаж, онцгой хорт бодис худалдах, ашиглах, тээвэрлэх, хадгалах, импортлоход тавих хяналтыг сайжруулна.	Жил бүр	Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагчид	
14	Уул уурхай болон бусад томоохон төслийг санхүүжүүлэгч байгууллагуудтай ногоон хөгжлийн бодлогыг холбох механизмыг бий болгоно.	Жил бүр	Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагчид	
15	Уул уурхайн нөхөн сэргээлтэд “дүйцүүлэн хамгаалах” механизмыг нэвтрүүлнэ.	Жил бүр	Газрын даамал	
16	Цөлжилтөөс сэргийлж, бэлчээрийн талхлахыг бууруулах зорилгоор бэлчээр, усны цогц бодлогыг хэрэгжүүлэх, булаг шанд хамгаална.	Жил бүр	Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагчид	
17	Уул уурхай, хүнд даацын авто замаар сүйтгэгдсэн бэлчээрийн болон бусад талбайг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.	Жил бүр	Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагчид	
18	Сумын батлагдсан хил хязгаарыг зураг, техникээр нарийвчлан тогтоож, хилийн заагаар нутагладаг гадны малчид, сумын бүх иргэдэд таниулан сурталчилна.	Жилдээ	Байгаль орчны байцаагч, Газрын даамал	

19	Ховордож байгаа Загийн нөөц бүхий газруудын загийг хамгаалж, төсөл хөтөлбөртэй хамтран нөхөн сэргээх, хортой шавьж хорхойг устгана.	Жил бүр	Газрын даамал		
20	Сумын хэмжээний бүх худгийг газар зүйн нарийвчилсан байршлаар тогтоож бүртгэлд оруулна.	Жилдээ	Газрын даамал, Байгаль орчны байцаагч БЗД нар		
21	Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж хариуцлага тооцож ажиллана.	Жилдээ	ИТХ, Цагдаагийн хэсэг А.Эрдэнэбат		
22	Орон нутгийн цагдаагийн хэсэгт зохих техникийн дэмжлэг үзүүлж, “Драгер” согтууруулагч хэмждэг багажтай болгох	Жилдээ	А.Эрдэнэбат		
23	Цагдаагийн кабоныг интернетэд холбох	Жилдээ	А.Эрдэнэбат		
24	Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй буюу хууль бусаар худалдаж болох цэгүүдэд гэнэтийн шалгалт хийх зэрэг арга хэмжээг явуулсанаар Архигүй баярын өдрүүдийг тэмдэглэдэг сум, хамт олон болно.	Тогтмол	Цагдаагийн хэсэг ГХУССалбар зөвлөл		

ДЭД ХӨТӨЛБӨР - 4

ЗААЛТ – 80

НЭГТГЭЖ БОЛОВСРУУЛСАН : ЗДТГ-ЫН ДАРГА

Б. ХОРЛОО